

АГУУЛГА

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ.....	2
ЗУРГИЙН ЖАГСААЛТ.....	3
ҮҮСЭЛ ХӨГЖИЛ, ТАНИЛЦУУЛГА.....	4
АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН ТОО.....	5
ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН.....	6
АЖ ҮЙЛДВЭРИЙН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН.....	8
БАРИЛГА.....	9
ХУДАЛДААНЫ САЛБАРЫН ҮҮСЭЛ ХӨГЖИЛ, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ.....	12
ХОЛБООНЫ САЛБАР.....	13
ТЭЭВЭР ҮЙЛЧИЛГЭЭ.....	14
ДҮГНЭЛТ.....	15

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

1. Аж ахуйн нэгж байгууллагын тоо /эдийн засгийн үйл ажиллагааны салбараар/
2. Дотоодын нийт бүтээгдэхүүн салбарын ангилалаар /тэрбум.төг/
3. Аж үйлдвэрийн борлуулсан бүтээгдэхүүн /оны үнээр/
- 3.1 Гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт
4. Барилга угсралт, их засварын ажил /сая.төг/
- 4.1 Шинээр ашиглалтанд оруулсан барилга, байгууламжууд /сумдаар
5. Худалдааны салбарын гүйцэтгэл сонгогдсон аж ахуйн нэгж байгууллагаар
6. Холбооны салбарын үзүүлэлт

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

1. Аж ахуйн нэгж байгууллагын тоо, оноор
 - 1.1 Аж ахуйн нэгж байгууллагын тоо, бүтцээр
2. Дотоодын нийт бүтээгдэхүүнд / салбарын эзлэх хувь/
 - 2.1. Нэг хүнд ногдох днб / сая.төг/
3. Дээрх бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг 2012 оны борлуулалтаар нь авч үзвэл
 - 3.1. Гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт
4. Барилга угсралт, их засварын ажил /сая.төг/
 - 4.1. Ашиглалтанд оруулсан барилга байгууламж /тоо/
5. Нийт орлого /сая.төг/
6. Холбооны салбарын үзүүлэлт

АЙМГИЙН АЖ ҮЙЛДВЭР, БАРИЛГА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН ҮҮСЭЛ ХӨГЖИЛ, ТАНИЛЦУУЛГА

Манай аймаг анх 1942 онд байгуулагдаж жилдээ 562.6 мянган төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг барилга, оёдлын 2 артель бүхий үйлдвэр хоршооллын артель, цэцгийн тос боловсруулах завод 4, талхны цех зэрэг үйлдвэр үйлчилгээний салбар бүхий жилдээ 700 орчим мянган төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг хүнсний үйлдвэр ажиллуулж байжээ.

Авто тээврийн баазын харъяанд ЖЭС-60 маркийн 48 квт-ыг хүчин чадал бүхий дизель станц суурилуулан ашиглалтанд оруулснаар эрчим хүчний үйлдвэрийн анхны суурь тавигдсан бөгөөд өнөөдөр төв хөдөөгийн бүх сум төвлөрсөн эрчим хүчний хоёр талын эх үүсвэрт холбогдсон 24 цагийн найдвартай ажиллагаатай болж, хөдөөгийн малчин өрхийн 91.0 хувь нь сэргээгдэх эрчим хүчээр хангагдаад байна.

Анх 30 номерын гар телефон станцтай байжээ. Аймаг сүүлийн жилүүдэд холбоо харилцааны систем эрчимтэй хөгжиж бүх сум шилэн кабелийн сүлжээ, үүрэн холбооны 1-5 операторт холбогдсноор хүссэн цагтаа хэрэгцээт мэдээллээ олж авах, дэлхий аль ч өнцөгт холбоо тогтоох боломж бүрдээд байна.

2004-2007 онд манай аймгийн хувьд Цайрт минериал, Баянцогт мөнхийн гал 2009 онд Баян-Эрч, Эрвэн хүдэр гэх зэрэг тоомоохон уул уурхайн компаниуд байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж эхлээд байна.

Тэдгээр үзүүлэлтүүдийг гаргах мэдээллийн эх сурвалж нь үйлдвэрийн газруудын сар, улирал, жилийн тайлан, тооллого, судалгааны материал нь болдог.

2008 оноос эхлэн аж үйлдвэрийн бүтээгдэхүүнийг 2005 оны зэрэгцүүлэх үнээр тооцож байна.

Аж үйлдвэрийн салбарын ангилал:

Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар ангилахдаа НҮБ-ийн эдийн засгийн үйл ажиллагааны салбарын стандарт ангилал (ISCO.4.0)-ыг 2009 оноос эхлэн мөрдөж байна.

Хэд хэдэн төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, ажил үйлчилгээ эрхлэдэг нэгжийг тэдгээрийн дотор мэдэгдэхүйц өндөр хувийн жинтэй бүтээгдэхүүн, ажил үйлчилгээгээр нь үндсэн салбарт оруулдаг

АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН ТАЛААР

2012 оны бизнес регистрийн санд бүртгэлтэй 602 аж ахуйн нэгж, байгууллагаас үйл ажиллагаа явуулж байгаа нь 522 явуулахгүй байгаа нь 80 байна.

Үйл ажиллагаа явуулахгүй байгаа аж ахуйн нэгж байгууллагын шалтгааныг авч үзвэл: Үйл ажиллагаа эхлээгүй 25, бүрэн зогссон 19, түр зогсоосон 36 байна.

Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагын 47.5 хувийг ХХК, 22.6 хувийг Төсөвт байгууллага, 5.6 хувийг ЗБН, 6.5 хувийг ББН, 5.7 хувийг хоршоо, 9.8 хувийг Төрийн бус байгууллага, 1.7 хувийг Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, 0.4 хувийг Төрийн өмчит үйлдвэрийн газар, 0.2 хувийг Хувьцаат компани тус тус эзлэж байна.

Өмчийн хэлбэрээр авч үзвэл: 74.7 хувь буюу 390 нь хувийн, 25.5 хувь буюу 132 нь төрийн өмчтэй байна.


Мөн үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагын тоог эдийн засгийн салбарын ангилалаар хүснэгт 1-т харуулав.

ХҮСНЭГТ 1. АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН ТОО


/эдийн засгийн үйл ажиллагааны салбараар/

Салбарын нэр	2008	2009	2010	2011	2012
Бүгд	385	424	421	521	522
Хөдөө аж ахуйн, ан агнуур, ойн аж ахуй	12	15	12	16	24
Уул уурхай олборлох аж үйлдвэр	4	4	3	4	5
Боловсруулах аж үйлдвэр	8	8	7	19	18
Цахилгаан, дулааны үйлдвэрлэл, усан хангамж	5	5	3	5	5
Барилга	8	11	12	14	11
Бөөний ба жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйлчилгээ	110	135	154	167	174
Зочид буудал зоогийн газар	20	24	24	29	31
Тээвэр, агуулахын аж ахуй, холбоо	9	10	8	9	9
Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа	11	11	11	12	10
үл хөдлөх хөрөнгө түрээс, бизнесийн үйл ажиллагаа	8	8	10	26	24
Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгалын	47	50	50	48	49
Боловсролын үйл ажиллагаа	35	35	37	40	38
Эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа	58	58	54	59	61
Нийгэм, бие хүнд үзүүлэх бусад үйл ажиллагаа	50	50	36	73	63

ЗУРАГ 1. АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН ТОО, оноор



ЗУРАГ 1.1. АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН ТОО, бүтцээр



Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуйд 4.6 хувь, уурхай, олборлох аж үйлдвэрт 7.3 хувь, Цахилгаан, хий үйлдвэрлэл, усан хангамжид 1.0 хувь, Боловсруулах үйлдвэрт 3.4 хувь, Бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйл ажиллагааны салбарт 33.3 хувь, Зочид буудал зоогийн газарт 5.5 хувь, Тээвэр агуулахын аж ахуй, холбоонд 1.7 хувь, Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаанд 1.9 хувь, үл хөдлөх хөрөнгө түрээс бизнесийн үйл ажиллагаанд 4.6 хувь, Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгалд 9.4 хувь, боловсролын салбарт 7.3, Эрүүл мэндийн салбарт 11.7 хувь, Нийгэм бие хүнд үзүүлэх үйлчилгээнд 12.1 хувь нь тус тус үйл ажиллагаа явуулж байна.

ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН

Урьдчилсан гүйцэтгэлээр 2012 онд аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүн 225.6 тэрбум төгрөгт хүрсэн байна. Дотоодын нийт бүтээгдэхүүнийг салбараар нь авч үзвэл: Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуйн салбар нь өнгөрсөн оноос 58.0 хувиар 2008 оноос 2.6 дахин, Аж үйлдвэр, барилгын салбар нь өнгөрсөн оноос 32.5 хувиар 2008 оноос 44.2 хувиар, Үйлчилгээний салбар нь өнгөрсөн оноос 42.5 хувиар, 2008 оноос 93.5 хувиар тус тус өссөн байна.


ХҮСНЭГТ 2. ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН салбарын ангилалаар /тэрбум.төг/

Салбар	2008	2009	2010	2011	2012	%
Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй	37.1	34.7	48.0	62.1	98.1	158.0
Аж үйлдвэр, барилга	56.8	63.3	66.7	61.8	81.9	132.5
Үйлчилгээ	22.7	16.1	18.4	34.4	45.6	132.6
Дүн	116.6	114.0	133.1	158.3	225.6	142.5

ХҮСНЭГТ 2.1. ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНД / салбарын эзлэх хувь/


	2008	2009	2010	2011	2012
Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй	76.4	30.4	36.1	39.2	43.5
Аж үйлдвэр, барилга	4.6	55.5	50.1	39.1	36.3
Үйлчилгээ	19.0	14.1	13.8	21.7	20.2

ЗУРАГ 2. ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНД / салбарын эзлэх хувь/



Нэг хүнд ногдох ДНБ нь 2007 онд 2.7 сая, 2008 онд 2.1 сая, 2009 онд 2 сая, 2010 онд 2.4 сая, 2011 онд 2.8 сая, 2012 онд 4.1 сая төгрөг тус тус ногдож байна.


ЗУРАГ 2.1. НЭГ ХҮНД НОГДОХ ДНБ / сая.төг/



ХҮСНЭГТ 3. АЖ ҮЙЛДВЭРИЙН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН /оны үнээр/

Аж үйлдвэрийн салбар	2008	2009	2010	2011	2012	2012/ 2011 %
Уул уурхай, олборлох	72 690.8	98 775.1	101 081.6	94 520.5	138 136.0	146.1
Боловсруулах аж үйлдвэр	198.4	329.5	649.8	1 047.9	1 660.9	158.5
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах	2 670.1	2 837.5	2 916.8	3 783.0	4 025.8	106.4
Үүнээс: ус хуримтлуулан түгээх үйл ажиллагаа	217.8	222.1	230.1	243.0	304.1	125.1
ДҮН	75 559.3	101 942.1	104 648.1	99 594.4	144 126.8	144.7

ЗУРАГ 3. ДЭЭРХ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТИЙГ 2012 ОНЫ БОРЛУУЛАЛТААР



Гол нэр төрлийн бүтээгдэхүүнийг 2008 онтой харьцуулахад 2012 онд архинаас бусад бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж байна. Харин өнгөрсөн онтой зэрэгцүүлбэл: талх, нүүрс, улаан тоосго, цайрын баяжмал, нарийн боов, ул боовны үйлдвэрлэлт өсч, хиам, өнгөт тоосго, блок, замын хавтан, боржуур, эсгий, дулааны үйлдвэрлэлт буурч, төмрийн хүдэр, молибдений баяжмал, архи, цахилгааны үйлдвэрлэлт хийгдэхээ больсон байна.

ХҮСНЭГТ 3.1. ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ

Гол нэр төрлийн бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2008	2009	2010	2011	2012	2012/ 2011 %
Уул уурхай, олборлох аж үйлдвэр							
Нүүрс	мян.тн	113.1	60.9	119.6	191.9	402.5	209.7
Цайрын баяжмал	мян.тн	143.6	141.3	112.5	104.7	118.0	112.7
Төмрийн хүдэр	мян.тн	-	-	10.8	-	-	-
Молибдений баяжмал	мян.тн	-	0.5	0.1	-	-	-
Боловсруулах үйлдвэрлэл							
Талх	тн	79.2	109.0	329.2	425.5	580.5	136.4
Нарийн боов	тн	40.4	68.4	82.4	58.9	59.1	100.3
Ул боов	тн	-	-	24.4	19.3	20.6	106.7
Хиам	тн	-	4.2	2.8	4.2	3.2	76.2
Архи	мян.л	2.0	1.0	-	-	-	-
Блок	мян.ш	63.9	19.2	32.0	219.5	185.1	6.8*
Улаан тоосго	мян.ш	-	75.9	-	-	609.0	-
Өнгөт тоосго	мян.ш	-	15.8	11.3	13.6	10.0	73.5
Замын хавтан	м2	2 000.1	1 908.3	2 843.0	3 996.6	3 629.3	90.8
Боржуур	м3	...	46.8	39.9	200.2	166.9	5*
Эсгий	мян.м	0.8	6.8	2.8	4.0	2.8	70.0
Маягт	мян.х.д.х	-	22.7	-	-	-	-
Ном	мян.х.д.х	-	3.6	-	-	-	-
Цахилгаан, дулаан, усан хангамж үйлдвэрлэл							
Цахилгаан	мян.кв.цаг	272.5	248.1	-	-	-	-
Дулаан	мян. гкал	67.1	77.5	83.3	96.8	84.5	87.3

БАРИЛГА:

Бизнес регистрийн санд бүртгэлтэй барилгын үйл ажиллагаа явуулж байгаа 11 Аж ахуйн нэгж байгууллага байна. Аймгийн хэмжээнд 14.6 тэрбум төгрөгийн барилга угсралт, их засварын ажил хийсэн нь өнгөрсөн оноос 6.6 тэрбум төгрөгөр буюу 87.1 хувь, мөн 2008 оныхоос 4 дахин тус тус өссөн байна.

Нийт барилга угсралт, их засварын ажлын 3.7 тэрбумыг аймгийн барилгын байгууллага, 10.6 тэрбумыг гадны барилгын байгууллагууд тус тус гүйцэтгэсэн байна. Өнгөрсөн оноос аймгийн барилгын ажил 37.7 хувиар буурч, гадны гүйцэтгэгч байгууллагын ажил 6 дахин өссөн харагдаж байна.

2011 онд манай аймаг ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ХАНДИВЛАГЧ нарын уулзалтыг улсдаа анх удаа зохион байгуулсны үр дүнд гадны барилгын гүйцэтгэгч байгууллагууд тендэр болон харилцан гэрээ түншлэлээр манай аймаг уруу хандарч ажиллаж байгааг харуулж байна. Манай аймаг сүүлийн жилүүдэд их бүтээн байгуулалт хийж “ЖИШИГ АЙМАГ” болох зорилт тавьж ажиллаж байгаатай шууд

холбоотой юм. 2012 онд 19 барилга, байгууламж ашиглалтанд орсон бөгөөд өнгөрсөн оноос 35.7 хувиар, 2008 оноос 46.1 хувиар өссөн гүйцэтгэлтэй байна.

Нийт барилга угсралт, их засварын ажлын гүйцэтгэлийг төрлөөр нь авч үзвэл: Орон сууцны барилга 4.0 тэрбум төгрөг, орон сууцны бус барилга 4.6 тэрбум төгрөг, инженерийн барилга байгууламж 3.6 тэрбум төгрөгийн ажил тус тус хийгджээ.

ХҮСНЭГТ 4. БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ /сая.төг/

Үзүүлэлтүүд	2008	2009	2010	2011	2012	2012/ 2011
Барилга угсралт их, засварын ажил	3 449.6	1 750.2	5 656.3	7 624.4	14 267.5	187.1
Ашиглалтанд оруулсан барилга, байгууламж	13.0	17.0	14.0	14.0	19.0	135.7

ЗУРАГ 4. БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ /сая.төг/



ЗУРАГ 4.1. АШИГЛАЛТАНД ОРУУЛСАН БАРИЛГА БАЙГУУЛАМЖ /тоо/



2012 онд ашиглалтанд орсон барилга, байгууламжийн 47.4 хувь нь Баруун-Урт хотдоо байгаа бөгөөд 11.1 хувь нь орон сууц, 11.1 хувь нь конторын барилга, 77.8 хувь нь авто болон явган зам, шугам сүлжээний их бүтээн байгуулалтын ажлууд хийгдсэн байна.

Хөдөөгийн сумд 52.6 хувийг хийж гүйцэтгэжээ. Үүнд: Дарьганга сум нийт барилга, байгууламжийн ажлын 21.1 хувийг хийсэн бөгөөд сургууль, соёлын барилга, 0.4 квт-ын цахилгаан шугам бусад байгууламжийн ажил, Сүхбаатар сум 10.5 хувь болох сургууль, соёлын барилга, Уулбаян сумд 10.5 хувь болох конторын барилга, Баяндэлгэр, Халзан сумд 5.3 хувийн болох конторын барилга байгууламжуудыг тус тус барьж байгуулсан байна.

ХҮСНЭГТ 4.1. ШИНЭЭР АШИГЛАЛТАНД ОРУУЛСАН БАРИЛГА, БАЙГУУЛАМЖУУД

Байгууламжийн нэр	Хүчин чадал	Төсөвт өртөг /сая.төг/	Бүгд	Баруун-Урт	Баяндэлгэр	Дарьганга	Сүхбаатар	Түвшинширээ	Уулбаян	Халзан	Эрдэнэцагаан
Орон сууц	45 айл	309.0	1	1							
Онгоц буудлын авто замын дагуух явган зам	1485 м	47.2	1	1							
Төмөртэйн чиглэлийн авто замын дагуух явган зам	1650 м	49.8	1	1							
ХХҮХ-ийн контор	342 м2	520.0	1	1							
Авто зам	2.2 км	1 138.0	1	1							
Халуун усны барилга	5 хүний	83.9	1				1				
Багийн өвсний агуулах	20 тн	9.9	1			1					
Цэцэрлэгийн өргөтгөл	100 хүүхэд	129.1	1				1				
Цэцэрлэгийн өргөтгөл	75 хүүхэд	158.1	1			1					
Спорт урлагын өргөө	240 хүний суудалтай	1 100.0	1			1					
Цагдаагийн байр	107.1 м2	64.6	1						1		
Ахмадын байр	40.2м2	28.0	1						1		
ХАУС хороололын зам	300м	52.6	1	1							
Бичил хороолол	500м	24.1	1	1							
0.4 квт-ын ЦДАШ барих	1.8 км	42.4	1			1					
Цагдаагийн байр	117	65.0	1							1	
Сургуулийн дотуур байрны өргөтгөл	120 м2	49.9	1		1						
Захиргааны баруун талын авто зогсоол	25 машин	47	1	1							
Жишиг хороолол	140 айлын шугам сүлжээ	1 000.0	1	1							
Барилга, байгууламжийн дүн		4 918.5	19	9	1	4	2		2	1	

Тухайн аймгийн нутаг дэвсгэр дээр худалдааны үйл ажиллагаа явуулах, орчин нөхцөл бололцоо.

Сүхбаатар аймаг нь Монгол орны зүүн өмнөд хэсэгт 82.3 хавтгай дөрвөлжин км нутаг дэвсгэрийг эзлэн, урд талаараа БНХАУ, баруун талаараа Дорноговь, баруун хойт талаараа Хэнтий, зүүн талаараа Дорнод аймагтай тус тус хиллэдэг.

Аймаг 2012 онд 15.9 мянган өрх, 55.6 мянган суурин хүн амтай болсон бөгөөд нийт өрхийн 52.9 хувь буюу 8.5 мянган өрх аймаг, сумын төвд амьдарч байна.

Нийт хүн амын 48.9 хувь нь хөдөө, 51.1 хувь нь аймаг сумын төвд амьдарч байгаа ба 66.3 хувь нь 15-59 насны хөдөлмөрийн насны хүн байна.

ХУДАЛДААНЫ САЛБАРЫН ҮҮСЭЛ ХӨГЖИЛ, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ


Бизнес регистрийн санд бүртгэлтэй нийт аж ахуйн нэгж байгууллагын 33.3 хувь буюу 174 нь худалдааны салбарт үйл ажиллагаа явуулж байна. Худалдааны салбараас түүвэрлэгдсэн мэдээнд хамрагдаж үйл ажиллагаа явуулж байгаа 18 аж ахуйн нэгж байгууллагад 121 хүн ажиллаж байна.

Нийт борлуулалтын орлого 6.5 тэрбум төгрөг байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 13.7 хувиар буюу 784.2 сая төгрөгөөр өссөн гүйцэтгэлтэй байна.

ХҮСНЭГТ 5. ХУДАЛДААНЫ САЛБАРЫН ГҮЙЦЭТГЭЛ СОНГОГДСОН АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГААР

Үзүүлэлт	Нийт орлого /сая.төг/				Ажиллагсдын тоо				Мэдээлэлд хамрагдсан байгууллага			
	2009	2010	2011	2012	2009	2010	2011	2012	2009	2010	2011	2012
Эм, гоо сайхны барааны жижиглэн	79.4	146.9	63.6	256.0	17.0	8.0	6.0	28.0	1.0	1.0	2.0	2.0
Бусад төрөлжсөн дэлгүүрийн	1 812.7	2 830.9	5 648.6	6 240.4	29.0	72.0	77.0	93.0	19.0	19.0	33.0	16.0
Бүгд	1 892.1	2 977.8	5 712.2	6 496.4	46.0	80.0	83.0	121.0	20.0	20.0	34.0	18.0

ЗУРАГ 5. НИЙТ ОРЛОГО /сая.төг/



ХОЛБООНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО, РАДИО ЦЭГИЙН ТОО

Холбооны нийт орлого,үүнээс хүн амаас орсон орлого телефон болон радио цэгийн тоо зэрэг үндсэн үзүүлэлтийг харуулав.

Нийт орлого: Холбооны үйл ажиллагааны нийт орлого гэдэгт цахилгаан холбоо,хөдөлгөөнт холбоо,мэдээллийн технологи, шуудангийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагуудын тайлант хугацааны нийт орлогыг оруулна.

Үүрэн телефон хэрэглэгч: Тухайн байгуулсан сүлжээний хүрээнд хөдөлгөөнтэй /нэгээс нөгөө үүрт шилжих/ашиглах боломжтой утасгүй холбооны хэрэглэгч юм.

Утасгүй холбооны хэрэглэгч: Тухайн байгуулсан сүлжээний хүрээнд ажиллах радио долгионы холбооны хэрэглэгч .

Интернет кафе: Олон нийтэд нэг цэгт интернет үйлчилгээ үзүүлэгч байгуулагаа аж ахуйн нэгж


2012 онд 488.2 сая.төг болсон нь өнгөрсөн оны мөн үеэс 43.6 хувь буюу 148.3 сая төгрөгөөр өссөн байна. Хүн амаас орох орлого нь 223.0 сая,төг болж өнгөрсөн оноос 33.8 хувиар өсч 56.3 сая.төг болжээ. Нийт орлогын 45.7 хувийг хүн амаас орох орлого эзэлж байна.

Суурин телефон цэгийн тоо 757 болж өнгөрсөн оны мөн үеэс 7.6 хувь буюу 138-аар буурсан байна.

ХҮСНЭГТ 6. ХОЛБООНЫ САЛБАРЫН ҮЗҮҮЛЭЛТ

Үзүүлэлт	хэмжих нэгж	2009	2010	2011	2012	%
Нийт орлого	сая.төг	333.1	324.1	339.9	488.2	143.6
Хүн амаас орох орлого	сая.төг	145.3	156.7	166.7	223.0	133.8
Телефон цэг	ш	1 090.0	935.0	819.0	757.0	92.4

ЗУРАГ 6. ХОЛБООНЫ САЛБАРЫН ҮЗҮҮЛЭЛТ



ТЭЭВЭР ҮЙЛЧИЛГЭЭ

Тээврийн салбарын статистик үндсэн үзүүлэлтүүдэд ачаа эргэлт, тээсэн ачаа, зорчигч эргэлт, авто машины тоо, шилжүүлсэн тонн.км, ажиллагсдын тоо орлого зэрэг орно

Авто тээврийн статистик мэдээ тайланг аж ахуйн нэгжүүдээс аймгийн статистикийн хэлтэс цуглуулан авч нэгтгэн Үндэсний статистикийн хороонд дамжуулдаг,

Ачаа эргэлт: Нийт тээвэрлэсэн ачааны хэмжээг зөөвөрлөсөн зайгаар үржүүлсэн үзүүлэлт

Зорчигч эргэлт: Нийт зорчигчдын тоог тээвэрлэсэн зайгаар үржүүлсэн хэмжээ

Шилжүүлсэн тонн км: Тээврээр гүйцэтгэсэн олон төрөл хэлбэрийн ажил үйлчилгээг тусгай коэффициентийг ашиглан нэг нэгжид шилжүүлж тооцно.

Тээвэр бүхий байгууллагууд 2012 онд 221.1 мян.тн ачаа тээвэрлэж, 55.3 сая.тн.км-ийн ачаа эргэлт хийсэн нь өнгөрсөн оноос тээсэн ачаа 17.9 хувиар буюу 33.5 мян.тн-оор, ачаа эргэлт 20.4 хувиар буюу 9.4 сая.тн.км-ээр тус тус өссөн гүйцэтгэлтэй байна. Тээвэр бүхий байгууллагууд 59.2 мян.хүн тээвэрлэж, 33.5 сая.хүн.км-ийн зорчигч эргэлт хийсэн нь өнгөрсөн оноос Зорчигч тээвэрлэлт 2.4 дахин, буюу 34.1 мян.хүнээр, зорчигч эргэлт 2.8 дахин буюу 21.4 сая.хүн.км-ээр тус тус өссөн гүйцэтгэлтэй байна.

Тээврийн орлого өнгөрсөн оноос 53.1 хувь буюу 2.8 тэрбумаар өссөн байна.

ХҮСНЭГТ 7. ТЭЭВРИЙН САЛБАРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Үзүүлэлт	хэмжих нэгж	2009	2010	2011	2012	%
Тээсэн ачаа	мян.тн	188.2	175.3	187.6	221.1	117.9
Ачаа эргэлт	мян.тн.км	54 874.6	48 248.2	45 925.8	55 291.7	120.4
Зорчигч тээвэрлэлт	мян.хүн	13.6	22.8	25.1	59.2	235.9
Зорчигч эргэлт	мян.хүн.км	7 210.0	9 099.2	12 051.0	33 482.5	277.8

Манай аймгийн хэмжээнд 2012 онд авто техникийн улсын үзлэгээр бүх төрлийн авто машин 4.3 мянга болж өнгөрсөн оноос 10.3 хувиар буюу 0.4 мянгаар өссөн байна. Авто машиныг төрлөөр нь авч үзвэл: 51.2 хувь буюу 2.2 мянга нь суудлын авто машин, 44.2 хувь буюу 1.9 мянга нь ачааны, 4.7 хувь буюу 196 автобус, 0.9 хувь буюу 38 нь тусгай зориулалтын авто машин байна.

Авто машины тоо өнгөрсөн оноос 10.9 хувиар буюу 0.4 мянгаар, 2010 оноос 22.1 хувиар, 2009 оноос 25.7 хувиар тус тус өссөн байна. Улсын үзлэгийн дүнтэй харьцуулбал: нийт авто машины тоо 1.3 хувийг эзэлж байна.

ХҮСНЭГТ 7.1. АВТО МАШИНЫ ТОО УЛСЫН ҮЗЛЭГЭЭР

Үзүүлэлт	2009	2010	2011	2012	төрлөөр			тусгай зориулалтын
					суудлын	Ачааны	автобус	
Авто машины тоо	3 427	3 529	3 884	4 309	2 160	1 915	196	38
Улсын дүн	224 068	254 486	312 542	345 473	228 650	83 718	21 642	11 463

ХҮСНЭГТ 7.1. АВТО МАШИНЫ ТОО УЛСЫН ҮЗЛЭГЭЭР



ДҮГНЭЛТ, САНАЛ

Сүүлийн жилүүдэд улсын хэмжээнд явагдаж буй хөдөлмөр эрхлэлтийг дэмжихтэй холбоотойгоор олгогдож байгаа зээлээс улбаалан аж үйлдвэрийн гол нэр төрлийн бүтээгдэхүүн, нийт үйлдвэрлэлт, борлуулалтыг нэмэгдүүлж байна.

Эдийн засгийн үзүүлэлтээр улсад 2012 онд 2-р байр эзлэж байна. 2012 онд нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 4,1 сая төгрөг болсон байна.

Аймгийн худалдаа, үйлчилгээний салбарт бизнесийн таатай орчин бүрдэж, бизнес эрхлэж амьдрал ахуйгаа дээшлүүлж байгаа иргэдийн тоо нэмэгдэж, ард иргэдийн амьдрал дээшилж байгаа бөгөөд манай аймгийн худалдааны салбарт нөлөөлөх нэг давуу тал нь БНХАУ-тай хөрш зэргэлдээ оршиж худалдаа наймаагаа хөгжүүлж байгаа явдал юм.

Тухайн аймгийн худалдааны салбарын нийт орлого жил ирэх тутам өсч байгаа нь манай хувийн хэвшилд ажиллаж байгаа иргэд, бизнес эрхлэгчдийн маань

хүчин зүтгэл, мөн банкны байгууллагуудын жижиг бизнес эрхлэгчдийг дэмжиж олгож байгаа зээл, бөөний сүлжээний төв байгуулж төсөл хэрэгжүүлж ажиллаж байгаа нь нөлөөлж байна.

Үйлдвэр хоршооллын харьяа барилгын артелиар сууриа тавьсан аймгийн барилга угсралтын контор нь 1000 гаруй ажиллагсадтай барилгын материалын иж бүрэн үйлдвэр болон иж бүрэн өргөжсөн ч зах зээлийн давалгаанд барилгын улсын үйлдвэр задарч олон жижиг компани болон үйлдвэрлэлийн хүчин чадал нь урьд хүрсэн түвшингээсээ ухарсан хэдий ч сүүлийн жилүүдэд үйлдвэрлэлтийн хэмжээ сэргэж байна.

2009 оноос манай аймагт тээвэр авто замын газар байгуулагдсан нь тээврийн салбарын үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах таатай орчинг бүрдүүлсэн.

Хүн амын ажиллах амьдрах ая тухтай орчныг бүрдүүлэхэд төв суурин газрын тохижилт нэн чухал гэж үзэж сүүлийн 4 жилд хатуу хучилттай авто зам 12.6 км, явган хүний зам 9.2 км, авто зогсоол, талбай 3264 м²-ыг ашиглалтанд оруулаад байна.

Тус аймгийн тээврийн салбарын дийлэнх хэсэг нь хувьчлагдаж, хувийн тээврийн үйлчилгээ зонхилж байгаа ч шуудан тээврийн үйлчилгээ сэргэж, авто вокзал шинээр баригдаж шинээр нэгдсэн зохион байгуулалтад орж байна.

Одоо Улаанбаатар Баруун-Урт хоёрын хооронд хоногт 2 удаа, аймгийн урд талын сумдад 7 хоногт 1 удаа зорчигч тээврийн үйлчилгээг нийслэлээс шууд үзүүлдэг, хөдөөгийн сумдад аймгийн төвөөс 7 хоног бүрт шуудан хүрч үйлчилж байна. Иймд тээврийн салбарын үзүүлэлтүүд сүүлийн жилүүдэд жилээс жилд өссөн үзүүлэлтэй байна.

Сүүлийн жилүүдэд холбоо харилцааны систем эрчимтэй хөгжиж бүх сум шилэн кабелийн сүлжээ, үүрэн холбооны 1-5 операторт холбогдсноор хүссэн цагтаа хэрэгцээт мэдээллээ олж авах, дэлхий аль ч өнцөгт холбоо тогтоох боломж бүрдээд байна. Үүнтэй зэрэгцээд холбооны салбарын үзүүлэлтийн нэг болох суурин утасны тоо жил ирэх тутам унаж байна.

Үүрэн телефоны операторууд манай аймагт иргэд хөдөлмөрчдийн хэрэгцээг хангаж ажиллаж байгаа нь нэг талаар сайн үзүүлэлт боловч, зах зээлийн өрсөлдөөн ихтэй, төвдөө төвлөрсөн удирдлагатай тайлан баланс гардаггүй гэдгээр манай статистик мэдээлэлд хамрагдах боломжгүй байдаг нь бидний хувьд ямарч мэдээлэл дүгнэлт байдаггүй нь дутагдалтай.

Гэвч холбооны салбарын эдийн засгийн үзүүлэлтийн нэг болох суурин утасны тоо жил ирэх тутам унаж байна.

Хойшид үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээрхи санал:

- Шинээр худалдааны чиглэлээр бий болж байгаа ААН Байгууллагууд онцгой зөвшөөрөл авахын тулд 1-2 хүний бүрэлдхүүнтэй ХХК болж үүсч байгаа нь санхүүгийн талаар ямар ч мэдэгдэхүүнгүй нэг гэрийн хоёр хүн дарга, нягтлан гэж бүртгүүлснээс статистикийн мэдээ тайлан гаргах, АШБ хөтлөх талаар ямар ч ойлгоцгүй байна. Иймд ААН Байгууллага шинээр бий болоход тодорхой босго тавьж өгөх шаардлага гарч байна.
- Манай статистикийн 21-ний мэдээний хугацаатай ААН-ийн мэдээлэл таардаггүй энэ нь мэдээг 15-наас авдаг учир тайлан гараагүй байдагтай холбоотой юм.
- Үүрэн телефоны операторууд манай аймагт иргэд хөдөлмөрчдийн хэрэгцээг хангаж ажиллаж байгаа нь нэг талаар сайн үзүүлэлт боловч, зах зээлийн өрсөлдөөн ихтэй, төвдөө төвлөрсөн удирдлагатай тайлан баланс гардаггүй гэдгээр манай статистик мэдээлэлд хамрагдах боломжгүй байдаг Хойшид үүрэн телефонууд аймагтаа нэгдмэл удирдлаган дор мэдээлэлд хамрагдаж байх нь хуулийн заалтад нийцэх юм.
- Манай аймагт бүртгэлтэй хотоос үйл ажиллагаагаа удирдаж явуулж байдаг тээврийн компани байна. Энэ компанийн мэдээллийг оршин байгаа дүүргийн статистикийн хэлтсээр авахуулж авч болох эсэх.

Энэхүү судалгааны хамрах хугацаа нь 2008 2009, 2010, 2011,2012 оны гүйцэтгэлээр харууллаа.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ:

Жилийн эцсийн мэдээ, тайлан

ДНБ-ний тооцоо улс, аймаг, он оны статистикийн эмхтгэл

Хүн ам өрхийн бүртгэлийн сангийн үзүүлэлт зэргийг ашиглав.

ТАНИЛЦУУЛГА БИЧСЭН

Ц.ХАД

Ц. АЛТАНЦЭЦЭГ